

МОНГОЛ УЛСЫН САЙД, ОЛИМП, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД 2024 ОНЫ ХАГАС ЖИЛ
ГЭРЭЭНИЙ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ

№	Заалт	Хэрэгжилт
2.2.1	Аймгаас зохион байгуулж буй спортын тэмцээн, нийтийн биеийн тамирын арга хэмжээний үеэр оролцогч нараас эмх цэгц, сахилга дэг, ариун цэврийн стандартыг сахихыг шаардаж уламжлалт мэндлэх, хүндлэх, талархах, хүлээцтэй хандах ёсыг баримтлахыг эрмэлзэх	Арга хэмжээ, уралдаан тэмцээн бүрийг “Эерэг хандлага Эрүүл нийгэм” аяны хүрээнд эмх цэгц, сахилга дэг журам, цэвэр цэмцгэр орчинд стандартыг сахин зохион байгууллаа. Мөн А заалны 2 хаалгыг өргөсгөн, нугасыг сольж, заалны доторх өндрийн ажилы гүйцэтгэхэд ХАБЭА-г хангах нөхцлийг бүрдүүлэх 12м өндөр хайчин өргүүрийг авч үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн ба 6м хүртэлх өргөнтэй баннер өргөгчийг ажилчдынхаа хүчээр шинээр хийж гүйцэтгэлээ.
2.2.2	Нийтийн биеийн тамирыг дэмжих орчныг бий болгох, биеийн тамир, спортын арга хэмжээнд орон нутгийн иргэдийг өргөнөөр оролцуулахад шаардагдахад санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх, нийтийн биеийн тамирын барилга, цогцолборын үйл ажиллагааг хэвийн явуулах зардлыг шийдвэрлэх	Бүх нийтийн болон нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн улсын төсөт хөрөнгийг суулгаж өгснөөр 2024 оны хагас жилийн байдлаар Жаргалтхаан суманд 8 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургуультайгаа хамт шинэ заал, Баянмөнх суманд 1.9 тэрбум төгрөгийн өртөг бүхий шинэ заал, Өмнөдэлгэр суманд 9.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургуультайгаа цуг шинэ заал тус тус 3 сард ашиглалтанд орсон бол Биндэр суманд 1 тэрбум төгрөгийн өртөг бүхий шинэ заал гүйцэтгэл 95 % тай явагдаж байна.
2.2.3	Өсвөр үеийн шигшээ багийг 8-аас доошгүй төрлөөр байгуулж тамирчдын бэлтгэлийг ханган наадам, тэмцээнд оруулах, амжилтыг нэмэгдүүлэх болон бусад үйл ажиллагааг зохион байгуулах зардлыг шийдвэрлэн БТСТХуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтыг ханган ажиллах	Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг клубын системд шилжүүлэх зорилгоор 2021 оноос шигшээ багийн төрлүүд дээр спортын клубуудын тоог нэмэгдүүлэн ажиллаа. Үүнд: 2020 онд 6 спортын төрөлд 6 клуб, 2021 онд 9 спортын төрөлд 12 клуб, 2022 онд 9 спортын төрөлд 15 клуб, 2024 онд шигшээ багийн 10 спортын төрөлд 16 клуб үйл ажиллагаа явуулж байгаа нь шигшээ багийн тамирчдын техник, ур чадвар, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, өрсөлдөөнийг бий болгож, бодит үр дүнгээ өгч байгаа нь шигшээ багийн тамирчдын гол үзүүлэлт болох УАШТэмцээнд үзүүлсэн амжилт нь жил тутамд тогтмолжин, өсөж байгаагаар илэрхийлэгдэж байна.
2.2.4	Засаг дарга нь төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4, 60 дугаар зүйлийн 60.2.5, 65 дугаар зүйл, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлэх	- Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар хамаарах бүрэн эрхийнхээ хүрээнд санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг баримтлан биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр “Өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэн 150 сая төгрөг, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллах зорилгоор “Мөнхийн хайрын урсгал” НҮТББ-аас хэрэгжүүлсэн “” хөтөлбөрийн үйл ажиллагаанд 5 сая төгрөг, үндэсний

		спортын дэмжих 20 сая, Оюутны спортын наадамд 5 сая, төрийн албан хаагчдын спортын наадам 10 сая нийт 200 сая төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны зардлаас гарган зарцуулсан бол хүн амын нягтаршил, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн иргэний идэвхитэй хөдөлгөөн, спортоор хичээллэх боломжийг бий болгох спортын барилга байгууламж, заал талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Жаргалтхаан суманд 8 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургуультайгаа хамт шинэ заал, Баянмөнх суманд 1.9 тэрбум төгрөгийн өртөг бүхий шинэ заал, Өмнөдэлгэр суманд 9.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургуультайгаа цуг шинэ заал тус тус улсын төсөвт хөрөнгөөр 3 сард ашиглалтанд орсон бол Биндэр суманд 1 тэрбум төгрөгийн өртөг бүхий шинэ заал гүйцэтгэл 95 % тай явагдаж. -Орон нутагт спортын хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй болно.
2.2.5	Төсвийн ерөнхийлөн захирагчаас Засгийн газар зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар эрх, шилжүүлсэн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 2 дугаар албан даалгаварын дагуу сонгон шалгаруулж гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналт тавих	Төсвийн ерөнхийлөн захирагчаас Засгийн газар зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар эрх, шилжүүлсэн хөрөнгө оруулалтаар худалдан авах бараа, ажил үйлчилгээ хийгдээгүй болно.
2.2.6	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2-р зүйлд тусгагдсан нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхитэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжих зорилтыг өөрийн аймагт зохион байгуулах	Идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэвшил бүхий иргэн, гэр бүлийг дэмжих, биеийн тамир, спортоор хичээллэх ач холбогдлыг ойлгуулах мэдлэг, мэдээлэл олгох, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, спортын ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор 2024 оны хагас жилийн байдлаар БТСГазар нь "Мөнхийн хайрын урсгал" төрийн бус байгууллага, "Сувдан" бүжгийн клубтай тус тус хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж өглөө бүр 06:00 цагаас 07:30 цагийн хооронд иргэдэд үнэ төлбөргүй биеийн тамирын үйлчилгээ / өглөөний дасгал,шугаман бүжиг, нийтийн бүжиг, бүх насныханд софт волейбол, бадминтон зэрэг төрлүүдээр чөлөөт

		тоглолт/ үзүүлэн ажиллаж байна. Биеийн тамирын 45 арга хэмжээ , БТТТогтоох сорилыг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт Биеийн тамирын арга хэмжээнд давхардсан тоогоор 12100 иргэн хамрагдсан нь 2023 оны мөн үетэй харьцуулахад 500-аар өссөн үзүүлэлттэй байна.
2.2.7	Аймгийн биеийн тамир, спортын байгууллагын даргыг ажилд томилох, ажлаас чөлөөлөхдөө биеийн тамир, спортын тухай хуульд заасны дагуу зөвшилцөх	Биеийн тамир спортын газрын дарга тогтвор суурьшилтай 9 дахь жилдээ ажиллаж байна.
2.2.8	БТСТХуулийн 8.1.4 зүйлийг хэрэгжүүлж аймгийн 4 суманд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах, цаашид бүх сумдыг арга зүйчтэй болгох бэлтгэл ажлыг хангах	Дадал, Батноров, Батширээт, Хэрлэн, Мөрөн, Баянмөнх сумдад биеийн тамирын орон тооны арга зүйч ажиллаж байгаа нь 2023 онтой харьцуулахад 3 сум шинээр арга зүйчтэй болсон байна.Цаашид бүх сумдыг арга зүйчтэй болгох чиглэлийг сумдын Засаг дарга нарт өгч, хамтран ажиллах гэрээнд заалт болгон оруулсан.
2.2.9	Иргэдийг хүмүүнлэг, эрүүл чийрэг, бүтээлч зан чанарыг эрхэмлэн өдөр тутмын дасгал хөдөлгөөн, зөв хооололт, эрүүл амьдралын талаар орон нутагт түгээх ажлыг зохион байгуулах	Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн , Биеийн тамир, спортын тухай хууль, “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийн 2.2 дахь заалт, аймгийн Засаг дарга салбарын сайдтай байгуулсан гэрээний 2.2.9, 2.2.10 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэвшил бүхий иргэн, гэр бүлийг дэмжих, биеийн тамир, спортоор хичээллэх ач холбогдлыг ойлгуулах мэдлэг, мэдээлэл олгох, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, спортын ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор “2024 оны хагас жилийн байдлаар БТСГазар нь "Мөнхийн хайрын урсгал" төрийн бус байгууллага, "Сувдан" бүжгийн клубтай тус тус хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж өглөө бүр 06:00 цагаас 07:30 цагийн хооронд иргэдэд үнэ төлбөргүй биеийн тамирын үйлчилгээ / өглөөний дасгал,шугаман бүжиг, нийтийн бүжиг, бүх насныханд софт волейбол, бадминтон зэрэг төрлүүдээр чөлөөт тоглолт/ үзүүлэн ажиллаж байна. Биеийн тамирын 45 арга хэмжээ , БТТТогтоох сорилыг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт Биеийн тамирын арга хэмжээнд давхардсан тоогоор 12100 иргэн хамрагдсан нь 2023 оны мөн үетэй харьцуулахад 500-аар өссөн үзүүлэлттэй байна.
2.2.10	Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “Хүн	Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 03-64 насны 6500 иргэн хамрагдаж А,В үнэлгээтэй иргэдийн тоо 2467 байгаа нь 9,4%-аар

	амын бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил"-ын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж иргэдийг хамруулах, шинэ тогтолцоог бий болгоход хамтран ажиллах	өссөн. Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдаас А, В үнэлгээтэй иргэд нийт иргэдийн 37,9%
2.2.11	Багийн болон өвлийн, үндэсний спортын төрлийг онцгойлон анхаарч хөгжүүлэх, өвлөн уламжлуулах, сурталчилан таниулах ажлыг зохион байгуулах	Багийн болон өвлийн, үндэсний спортын төрлийг хөгжүүлэх, уламжлуулан сурталчлуулах зорилгоор: -Сар шинийн Үндэсний бөхийн барилдаан 6778000 төгрөг, -Волейболын Идэрчүүдийн УАШТэмцээнд оролцоход 3000000 төгрөг, -Хонхот бөмбөгийн УАШТэмцээнийг орон нутагт зохион байгуулахад 5000000 төгрөг, -Цанын өсвөр үеийн УАШТэмцээнд 1323000 төгрөг, -Өндөрхаан хайрхан тахилга Үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, морин уралдаан 3000000 -Хөл бөмбөгийн 21 аймгийн УАШТэмцээнд оролцоход 1000.000 төгрөгийг тус тус зарцуулсан байна.
2.2.12	Орон нутгийн алдартай тамирчин, дасгалжуулагчдаар ёс зүй, зөв хандлага төлөвшүүлэх, эрүүл идэвхитэй амьдралын хэв маягийг бий болгох талаар нийгэмд зөв зүйтэй үлгэр дууриалал болгох нөлөөллийн ажлыг зохион байгуулах	-Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээний үеэр дээд лигийн баг тамирчдыг урьж аймгийн Засаг даргын дэргэдэх Өсвөр үеийн шигшээ багийн тамирчдад цаг төлөвлөлт болон тамирчны ёс зүй, техник, тактик, ур чадварын ярилцлага, сургалтыг зохион байгууллаа. Арга хэмжээнд 31 багийн 341 өсвөрийн тамирчид хамрагдлаа.
2.2.13	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих хэрэгжүүлэх	Бүх нийтийн болон нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн улсын төсөт хөрөнгийг суулгаж өгснөөр 2024 оны хагас жилийн байдлаар Жаргалтхаан суманд 8 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургуультайгаа хамт шинэ заал, Баянмөнх суманд 1.9 тэрбум төгрөгийн өртөг бүхий шинэ заал, Өмнөдэлгэр суманд 9.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургуультайгаа цуг шинэ заал тус тус 3 сард ашиглалтанд орсон бол Биндэр суманд 1 тэрбум төгрөгийн өртөг бүхий шинэ заал гүйцэтгэл 95 % тай явагдаж байна.
2.2.14	Иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгөх ажиллагааг шуурхай, хүнд сурталгүй зохион байгуулж, шийдвэрлэлтэнд ахиц, дэвшилт гаргах	Иргэд, аж ахуй нэгж, байгууллагын өргөдөл хүсэлтийн дагуу: -Сар шинийн Үндэсний бөхийн барилдаан 6778000 төгрөг, -Цанын өсвөр үеийн УАШТэмцээнд 1323000 төгрөг, -Э.Бямбадоржийн хүсэлтээр "Жонжү кап" ОУТэмцээнд оролцоход 1000000 төгрөг, -Б.Далайцэрэнгийн хүсэлтээр "Жонжү кап" ОУТэмцээнд оролцоход 500000 төгрөг,

		-Ц.Амарсанаагийн хүсэлтээр Мутай боксын ДАШТэмцээнд оролцоход 1000000 төгрөг, -Хүндийн өргөлтийн УАШТэмцээнийг орон нутагт зохион байгуулахад 4000000 төгрөг, -Волейболын Идэрчүүдийн УАШТэмцээнд оролцоход 3000000 төгрөг, -Хонхот бөмбөгийн УАШТэмцээнийг орон нутагт зохион байгуулахад 5000000 төгрөг, -П.Энхманлайгийн хүсэлтээр Пара хөнгөн атлетикийн ДАШТэмцээнд оролцоход 3000000 төгрөг, -Б.Цэнджавын хүсэлтээр ДАШТэмцээнд оролцоход 500000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлж, өргөдөл, хүсэлтийн дагуу 26101000 төгрөгийн асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.
--	--	---